

Бага насны хүүхэдтэй гэр бүлүүд: Та Mixed Delivery-ийн талаар мэдэх үү?

Mixed Delivery гэж юу вэ?

Виржиниа муж улсын Mixed Delivery хөтөлбөр нь шаардлага хангасан нярай, бага насны болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд хямд үнээр **эсвэл үнэ төлбөргүйгээр жилийн турш бүтэн өдрийн сургуулийн өмнөх болон хүүхдийн асрамжийн** үйлчилгээг үзүүлдэг.



хөтөлбөрийн тусламжтайгаар Виржиниа муж улсын бага насны илүү олон хүүхэд чанартай сургуулийн өмнөх боловсрол болон хүүхэд асрахуйн үйлчилгээг авч, цэцэрлэгт орох бэлтгэлээ хангах боломжтой юм. Сургуулийн өмнөх болон хүүхэд асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь бага насны хүүхдүүдэд эрт математик сурах, бичиг үсэгт тайлагдах, бие даасан байдал зэрэг эрдмийн болон нийгэм/сэтгэл хөдлөлийн чухал үр чадваруудыг эзэмших боломжийг олгодог.

Миний хүүхэд хамрагдах боломжтой юу?

Хөтөлбөрт хамрагдахын тулд таны хүүхэд дараах шалгууруудын аль нэгийг хангасан байх ёстой. Үүнд:

- Хүүхдийн гэр бүл нь холбооны ядуурлын түвшний 200% ба түүнээс доош хэмжээний орлоготой бол
- Хүүхдийн гэр бүл орон гэргүй байгаа бол
- Хүүхдийн эцэг эх эсвэл асран хамгаалагч нь ахлах сургуулиа төгсөөгүй бол
- Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсвэл тусгай боловсрол эзэмших шаардлагатай бол

Танай гэрт амьдарч байгаа бүх насанд хүрсэн хүмүүс дараахын аль нэгийг хийдэг бол. Үүнд: ажил хийдэг, ажил хайж байгаа ба/буюу сургууль/сургалтад хамрагдаж байгаа, эсвэл өөрсдөө хүүхдээ асрах боломжгүй байгаа бол.

Таны хүүхэд Mixed Delivery хөтөлбөрт хамрагдах боломжтой эсэхийг шийдэхэд уг хөтөлбөрийн удирдагч тусална.



Mixed Delivery-д хамрагддаг сургуулийн өмнөх болон хүүхэд асрах хөтөлбөрүүдийг хаанаас олж болох вэ?

Таны бэлэн бүсийн Mixed Delivery-ийн удирдагч танай бүс нутагт хамрагдах боломжтой Mixed Delivery хөтөлбөрүүдийг олоход тань тусална. Илүү ихийг мэдэхийн тулд та Бэлэн бүстэйгээ холбогдоно уу.

READY REGION

Capital Area

Early Childhood Programs and Services (ECPS), Fairfax County
NCSMD-RRCA@fairfaxcounty.gov



Virginia Early Childhood Foundation
www.vecf.org

